



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Барилга, хот байгуулалтын яам

Нэгжийн нэр:

Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын нэр:

Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Яамны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, бодлого, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хууль эрх зүйн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төслийн санал боловсруулах, салбарын байгууллагуудын менежментийн тогтолцоог боловсронгуй болгох, тэдгээрийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна. /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын зорилт:

- 1.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хууль эрх зүйн орчин, норм, стандартыг боловсронгуй болгох, төслийн санал боловсруулах, санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- 3.Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагаанд хяналт тавих, бие даасан байдлыг хангахад бодлогын зохицуулалтаар хангах, мэргэжлийн удирдлага, дэмжлэг үзүүлж ажиллах;
- 4.Салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг бодлогын удирдамж, чиглэлээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, эдгээр байгууллагуудтай шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ мэдээллийг гаргуулан авах, харилцан солилцож, хамтран ажиллах, удирдлага зохицуулалтаар хангах.
- 5.Хууль тогтоомжоор олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүд, норм, дүрэм, журам стандартад үзлэг хийж, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр төсөл боловсруулах	Санал боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	2.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүд, норм, дүрэм, журам стандартын хэрэгжилтийг ханган ажиллах;	Бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан байна	Х, Г, Т
2 дугаар зорилтын хүрээнд	1.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;	Төсөл, арга хэмжээ хэрэгжих нөхцөл бүрдэнэ	Х, Г, Т
	2.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн талаарх төрийн бодлогыг ус хэрэглээ, менежментийн чиг хандлагатай уялдуулан хөтөлбөр, төслийг боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.	Хөтөлбөр, төсөл боловсруулж, батлуулсан байна.	Г, Х



3 дугаар зорилтын хүрээнд	1.Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	Бүтэц зохион байгуулалт, боловсронгуй болсон байна.	Х, Т, Г
	2.Салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд холбогдох байгууллага, газартай хамтран үзлэг хийж, зохих журмын дагуу үнэлэлт, дүгнэлт өгөх, санал боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	Салбарын байгууллагуудын хэвийн найдвартай ажиллах нөхцөл бүрдэнэ.	Х, Г, Т
	3.Салбарын байгууллагуудын санхүү, эдийн засгийн байдал, зээлийн эргэн төлөлтийн талаар судалгаа хийж, санал боловсруулж, шийдвэрлүүлэх;	Төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.	Г, Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авч байх, мэдээлэл байнга солилцож байх;	Санхүүгийн чадавхтай болж, бие даан ажиллах нөхцөл бүрдэнэ.	Г
	2.Салбарын хэмжээнд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг бодлогоор дэмжих, зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах;	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн байна.	Г, Т
	3.Салбарын бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ мэдээллийг гаргуулан авах, харилцан солилцож, хамтран ажиллах.	Мэдээлэл солилцож хамтран ажилласан байна.	Г, Х, Т
5 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;	Ёс зүйн болон бусад төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн байна.	Г, Х
	2.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;	Цаг хугацаандаа, шударгаар биелүүлж, гүйцэтгэсэн байна.	Г, Х
	3.Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн хийж гүйцэтгэсэн байна.	Г, Х
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		




Мэргэжил	- Хүрээлэн буй орчныг хамгаалах технологи /0712/; - яамны үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны чиглэлийн мэргэжлийн инженер.	
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	- Төрийн албанд 8 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүй эзэмшсэн байх; - мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг нэвтрүүлэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн технологи ашиглах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - жендерийн эрх тэгш байдлыг хангах; - авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.
IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u> - Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга		
<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u> - УИХ, ЗГ-ын харьяа төрийн захиргааны байгууллагууд; - Яам, агентлаг, нутгийн захиргааны	



	болон бусад төрийн байгууллагууд; - Төрийн бус байгууллагууд; - Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд; - Иргэн, хуулийн этгээд.
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
--	---

Албан тушаал: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  Д.БАЯРСАЙХАН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 20 10 14 Дугаар: 340
---	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  С.МАГНАЙСҮРЭН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр
--

